



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/91/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Сайншанд сум

2020 он

Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 99092469 Цахим хаяг: [ariunaach@audit.gov.mn](mailto:ariunaach@audit.gov.mn)

**Аудитын менежер: Э.Энхцэцэг**

Утас: 90077079 Цахим хаяг: [enkhtsetsege@audit.gov.mn](mailto:enkhtsetsege@audit.gov.mn)

**Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Уваа уул” аудит ХХК**

Утас: 99108763 Цахим хаяг: [uwaauul.audit@gmail.com](mailto:uwaauul.audit@gmail.com)

## Агуулга

|                                                                                                                               |    |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| 1. Аудитын гэрчилгээ .....                                                                                                    | 2  |
| 2. Аудитын тайлан.....                                                                                                        | 4  |
| 2.1. Оршил .....                                                                                                              | 4  |
| 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....                                                    | 4  |
| 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....                                                         | 4  |
| 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....                                                         | 5  |
| 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ..... | 5  |
| 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....                                                    | 5  |
| 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....                                                               | 6  |
| 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....                                                                                  | 6  |
| 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....                                                                     | 7  |
| 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....                                                                   | 7  |
| 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....                                            | 8  |
| 2.12. Шилэн дансны мэдээлэл.....                                                                                              | 8  |
| 2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....                                                   | 8  |
| 2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....                                                                                        | 8  |
| 3. Менежментийн захидал .....                                                                                                 | 9  |
| 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....                                                                                        | 10 |
| 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....                                                                               | 10 |
| 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....                                                                            | 11 |
| 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....                                                                               | 13 |
| 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....                                                                 | 15 |
| 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....                                                                            | 16 |
| 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....                                                                            | 18 |
| 5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....                                                                        | 19 |

### Товчилсон үгийн жагсаалт

|          |                                                             |
|----------|-------------------------------------------------------------|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт               |
| АОУС     | Аудитын Олон Улсын Стандарт                                 |

## 1. Аудитын гэрчилгээ

|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       |                                                                                           |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------|
| <br><b>ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ<br/>ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</b><br>44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,<br>3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,<br>Утас: (705) 2-27-34<br>Вэб сайт: dornogovi@audit.gov.mn                                                                                                                                                                           | <b>ХАТАНБУЛАГ СУМЫН ЕРӨНХИЙ<br/>БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН<br/>ЗАХИРАЛ Ч.НАНДИНЗАЯА ТАНАА</b> |
| 2020.02.28 № 1-6/208<br>танай _____-ны № _____-т                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |                                                                                           |
| <b>Аудитын гэрчилгээ</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |                                                                                           |
| <p>Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Хатанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>                                                                                                          |                                                                                           |
| <b>Зөрчилгүй санал дүгнэлт</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |                                                                                           |
| <p>Хатанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p>   |                                                                                           |
| <b>Санал дүгнэлтийн үндэслэл</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |                                                                                           |
| <p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>                           |                                                                                           |
| <p>Дорноговь аймгийн Хатанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p> |                                                                                           |


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Ч.Нандинзаяа Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020. оны 1 дүгээр сарын 2-ноос 2020 оны 2 дугаар сарын 16-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 16-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Уваа уул аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Уваа уул аудит” ХХК-д 2020 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн .... дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Суралцагчийг номоор дамжуулан төлөвшүүлж, хөгжүүлэхэд оршино.

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургалтыг чанартай зохион байгуулж сурлагын чанар ахиц гаргах, амьдрах ухааны суурь мэдлэг чадвар эзэмшүүлэх
- Багш ажилчдын нийгмийн асуудалд анхаарах, ажлын байрандаа хөгжих боломжийг дэмжих

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн албаны тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- ХАОАТ-ын тухай хууль
- Засгийн газрын 2019.01.09-ний өдрийн 05, 06, 07 дугаар тогтоол
- Засгийн газрын 2019.01.16-ны өдрийн 24, 25 дугаар тогтоол
- Засгийн газрын 2019.04.03-ны өдрийн 126 дугаар тогтоол
- Засгийн газрын 2019.10.30-ны 395 дугаар тогтоол

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ACOLOURS программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 13 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,974,587.9 мянган төгрөгөөс тооцон 19,745.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 19,745.9 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн үеэс өөрчлөгдөөгүй байна.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 679157.7 мянган төгрөгөөр буюу 45.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан , үндсэн хөрөнгө, Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт                                          | Эхний үлдэгдэл     | Эцсийн үлдэгдэл  | Өөрчлөлт           |
|---------------------------------------------------|--------------------|------------------|--------------------|
| <b>Б</b>                                          | <b>1</b>           | <b>2</b>         | <b>3=2-1</b>       |
| Мөнгөн хөрөнгө                                    | 0                  | 0                | 0                  |
| Авлага                                            | 5,225.2            | 4,208.8          | -1,016.4           |
| Урьдчилгаа                                        |                    |                  |                    |
| Бараа материал                                    | 65,591.8           | 75,191.9         | 9,600.1            |
| Үндсэн хөрөнгө                                    | 1,426,731.9        | 738,990.5        | -687,741.4         |
| <b>Нийт хөрөнгө</b>                               | <b>1,497,548.9</b> | <b>818,391.2</b> | <b>-679,157.7</b>  |
| Өр төлбөр                                         | 0                  | 00               |                    |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/               | 1,497,548.9        | 818,391.2        | (679,157.7)        |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>1,497,548.9</b> | <b>818,391.2</b> | <b>(679,157.7)</b> |

Авлага дансны үлдэгдэл буурсан нь авлагын эхний үлдэгдэл бүрэн барагдсан /хувь хүмүүсээс авах ёстой 5,000.0 мянган, мөн НДХэлтээс авах 225.2 мянган төгрөгийн/, тухайн оны явцад түрээсийн номын мөнгө 1,408.8 мянган төгрөгийн орлого орсон боловч данс хаагдсан байсан тул мөнгө шилжээгүй, мөн бага ангийн багшийг ажлын байран дээр нь хөгжүүлэх “Бидний ахиц - бидний амжилт” төслийн сургалт семинар зохион байгуулахад зориулагдсан үлдэгдэл 2,800.0 мянган төгрөг, нийт 4,208.8 мянган төгрөгийн эргүүлж авах ёстой үлдэгдэл байсан тул авлага үүсгэснээс шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд он удаан жил болсон, барагдах боломжгүй, эрсдэлтэй авлага байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь тайланд онд төсвийн хөрөнгөөр 116,068.0 мянган төгрөгийн материал, үнэ төлбөргүй 1,882.9 мянган төгрөгийн түрээсийн сурах бичиг, нийт 117,950.0 мянган төгрөгөөр материал нэмэгдэж, 108,350.9 мянган төгрөгийн зарлага гаргаснаас шалтгаалжээ. Бараа материалын дансны ашиглалтгүй бараа материал байхгүй байна. Оны эцэст 26,774.2 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь багш ажилчдын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх болон байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, багш ажилчдын ажлын байрны ажиллах нөхцөлийг хангахад зориулагдсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь хуримтлагдсан элэгдэл өссөнөөс шалтгаалжээ. 2018 онд хийгдсэн дахин үнэлгээгээр барилга, байгууламжийн ашиглалтын нийт хугацааг үлдэх ашиглалтын хугацаагаар тооцох болсноор тайлант хугацааны элэгдлийн зардал өндөр болжээ.

Худалдан авсан 18,923.9 мянган төгрөг, хандиваар 1,722.5 мянган төгрөг, шилжүүлэн авсан 38,031.9 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө шилжүүлсэн 38,031.9 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгийн үлдэгдэлд өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр данс оны эхэнд болон эцэст үлдэгдэлгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 818,391.2 мянган төгрөг болж 679,157.7 мянган төгрөгөөр буурсан нь Тайлант үеийн үр дүн -679,157.7 мянган төгрөг гарснаас шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга хийгдээгүй.

## **2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль тайлант онд 590,654.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 590,654.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 100.0 хувиар биелүүлсэн байна. Үүнээс 196.4 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрт зориулан 590,654.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 590,654.7 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 553,381.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 37,272.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 590,458.2 мянган төгрөг буюу 99.97 хувьтай байна. Батлагдсан төсөв 196.4 мянган төгрөгөөр хэмнэгдсэн. Үүнд: томилолт 67.1 мянга, НДШ 55.1 мянга, Байр ашиглалттай холбоотой 22.9 мянга, Бусдаар гүйцэтгүүлсэн 23.5 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 21.4 мянган төгрөгөөр хэмнэгджээ. Хэмнэгдсэн 196.4 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн.

**Нэмэлт төсөв:** “Бидний ахиц - бидний амжилт” төслийн 13,100.0 мянган төгрөг, түрээсийн номны 1458.0 мянган төгрөг, нийт 14,508.8 мянган төгрөг орж, 14,508.8 мянган төгрөгийг зарцуулсан. Хичээл үйлдвэрлэлийн зардалд 9,400.0 мянга, эд хогшил, урсгал засварт 3,700.0 мянга, бусдаар ажил, үйлчилгээ гүйцэтгүүлсний зардалд 1,408.8 мянган төгрөг зарцуулсан байна.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 13 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 6 эрсдэл тодорхойлж, нийт 19 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 156,479.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 155,825.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 654.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 654.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 144 мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 654.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тооцсон 19,745.9 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1. Цалингийн данстай холбоотой асуудал

##### 3.1.1. Илрүүлэлт:

Багшийн мэргэшлийн зэргийн нэмэгдэл авах ёсгүй байтлаа захирал Аймгийн засаг даргаар захирамж гаргуулан авсан. Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт “Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 2. “Төрийн үйлчилгээний албан хаагчийг мэргэжлийнхээ дагуу тухайн албан тушаал эрхэлж байх хугацаанд мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг үндэслэн албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож сар бүр олгоно.” тус тус зөрчсөн байна.

##### 3.1.2. Эрсдэл:

Зардал өсөх

##### 3.1.3 Өгсөн зөвлөмж:

Зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх

##### 3.1.1. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрөхгүй.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт                                                     | Эхний үлдэгдэл          | Эцсийн үлдэгдэл         |
|------------|-----------------------------------------------------------------------|-------------------------|-------------------------|
| 1          | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН                                               | <u>70,817,001.27</u>    | <u>79,400,687.27</u>    |
| 33         | АВЛАГА                                                                | <u>5,225,198.00</u>     | <u>4,208,800.00</u>     |
| 335        | Бусад авлага                                                          | <u>5,225,198.00</u>     | <u>4,208,800.00</u>     |
| 3351       | Байгууллагаас авах авлага                                             | <u>225,198.00</u>       | <u>4,208,800.00</u>     |
| 3352       | Хувь хүмүүсээс авах авлага                                            | <u>5,000,000.00</u>     | <u>00.00</u>            |
| 35         | БАРАА МАТЕРИАЛ                                                        | <u>65,591,803.27</u>    | <u>75,191,887.27</u>    |
| 351        | Түүхий эд материал                                                    | <u>13,528,700.28</u>    | <u>13,778,700.28</u>    |
| 35110      | Тусгай зориулалттай материал                                          | <u>13,528,700.28</u>    | <u>13,778,700.28</u>    |
| 354        | Хангамжийн материал                                                   | <u>52,063,102.99</u>    | <u>61,413,186.99</u>    |
| 35410      | Бичиг хэргийн материал                                                | <u>1,874,466.99</u>     | <u>7,701,266.99</u>     |
| 35420      | Аж ахуйн материал                                                     | <u>27,377,114.00</u>    | <u>36,969,024.00</u>    |
| 35440      | Түлш, шатах тослох материал                                           | <u>8,607,400.00</u>     | <u>1,807,000.00</u>     |
| 35460      | Хүнсний материал                                                      | <u>8,408,772.00</u>     | <u>9,140,546.00</u>     |
| 35470      | Бусад хангамжийн материал                                             | <u>5,795,350.00</u>     | <u>5,795,350.00</u>     |
| 2          | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН                                           | <u>1,426,731,954.28</u> | <u>738,990,545.04</u>   |
| 39         | ҮНДСЭН ХӨРӨНГӨ                                                        | <u>1,426,731,954.28</u> | <u>738,990,545.04</u>   |
| 392        | Биет хөрөнгө                                                          | <u>1,398,789,954.28</u> | <u>711,048,545.04</u>   |
| 39201      | Барилга, байгууламж, орон сууц                                        | <u>1,209,645,329.67</u> | <u>1,209,645,329.67</u> |
| 39202      | Хуримтлагдсан элэгдэл                                                 | <u>00.00</u>            | <u>-671,580,499.79</u>  |
| 39203      | Авто-тээврийн хэрэгсэл                                                | <u>19,000,000.00</u>    | <u>19,000,000.00</u>    |
| 39204      | Хуримтлагдсан элэгдэл                                                 | <u>-19,000,000.00</u>   | <u>-19,000,000.00</u>   |
| 39205      | Машин тоног төхөөрөмж (компьютер)                                     | <u>137,084,703.80</u>   | <u>172,943,525.91</u>   |
| 39206      | Хуримтлагдсан элэгдэл                                                 | <u>-84,827,721.80</u>   | <u>-124,001,413.63</u>  |
| 39207      | Тавилга, аж ахуйн эд хогшил                                           | <u>85,821,016.28</u>    | <u>81,536,570.73</u>    |
| 39208      | Хуримтлагдсан элэгдэл                                                 | <u>-49,040,155.46</u>   | <u>-47,074,968.37</u>   |
| 39214      | Бусад үндсэн хөрөнгө                                                  | <u>96,262,060.15</u>    | <u>83,539,623.59</u>    |
| 39215      | Хуримтлагдсан элэгдэл                                                 | <u>-9,761,324.56</u>    | <u>-9,360,169.27</u>    |
| 39217      | Ном                                                                   | <u>13,606,046.20</u>    | <u>15,400,546.20</u>    |
| 393        | Биет бус хөрөнгө                                                      | <u>27,942,000.00</u>    | <u>27,942,000.00</u>    |
| 39301      | Програм хангамж                                                       | <u>400,000.00</u>       | <u>400,000.00</u>       |
| 39302      | Хуримтлагдсан элэгдэл                                                 | <u>-400,000.00</u>      | <u>-400,000.00</u>      |
| 39303      | Бусад биет бус хөрөнгө                                                | <u>27,942,000.00</u>    | <u>27,942,000.00</u>    |
| 3          | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II                                           | <u>1,497,548,955.55</u> | <u>818,391,232.31</u>   |
| 5          | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН                                              | <u>1,497,548,955.55</u> | <u>818,391,232.31</u>   |
| 51         | Засгийн газрын хувь оролцоо                                           | <u>1,497,548,955.55</u> | <u>818,391,232.31</u>   |
| 511        | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | <u>347,364,469.71</u>   | <u>347,364,469.71</u>   |
| 51101      | Өмч: - төрийн                                                         | <u>347,364,469.71</u>   | <u>347,364,469.71</u>   |
| 512        | Хуримтлагдсан үр дүн                                                  | <u>754,763,368.61</u>   | <u>75,605,645.37</u>    |
| 51210      | Өмнөх үеийн үр дүн                                                    | <u>754,763,368.61</u>   | <u>754,763,368.61</u>   |
| 51220      | Тайлант үеийн үр дүн                                                  | <u>00.00</u>            | <u>-679,157,723.24</u>  |
| 51300      | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                                      | <u>395,421,117.23</u>   | <u>395,421,117.23</u>   |
| 6          | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V                           | <u>1,497,548,955.55</u> | <u>818,391,232.31</u>   |

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт                                                                                                   | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------|-----------------------|
| 1          | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)                                                                            | 637,394,700.00      | 608,768,900.00        |
| 12         | ТАТВАРЫН БУС ОРЛОГО                                                                                        | 92,438,900.00       | 5,014,200.00          |
| 120        | Нийтлэг татварын бус орлого                                                                                | 92,438,900.00       | 5,014,200.00          |
| 120004     | Төсөв байгууллагын өөрийн орлого                                                                           | 92,438,900.00       | 5,014,200.00          |
| 1200042    | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих                                                                  | 00.00               | 1,408,800.00          |
| 1200045    | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого                                                                          | 92,438,900.00       | 3,605,400.00          |
| 13         | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО                                                                              | 1,200,000.00        | 50,372,900.00         |
| 131007     | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих                                                                   | 543,755,800.00      | 553,381,800.00        |
| 1311       | Нэмэлт санхүүжилтийн орлого                                                                                | 1,200,000.00        | 13,100,000.00         |
| 131104     | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,200,000.00        | 13,100,000.00         |
| 1320       | Орон нутгийн төсвөөс санхүүжих                                                                             | 00.00               | 37,272,900.00         |
| 132001     | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/                                        | 00.00               | 37,272,900.00         |
| 2          | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН                                                                                | 577,741,791.45      | 1,287,926,623.24      |
| 21         | УРСГАЛ ЗАРДАЛ                                                                                              | 577,741,791.45      | 1,287,926,623.24      |
| 210        | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                                                                            | 532,426,222.45      | 1,267,444,765.13      |
| 2101       | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                                                                          | 328,417,166.00      | 402,310,199.00        |
| 210101     | Үндсэн цалин                                                                                               | 328,417,166.00      | 402,310,199.00        |
